

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 12 дугаар сарын 12-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-4

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 5-20

<i>1.Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын “Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</i>	5-12
<i>2.Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцид 2016, 2018 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</i>	12-18
<i>3.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/</i>	18-19
<i>4.“Ажлын хэсэг тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /“Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/</i>	19-20

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
12 дугаар сарын 12-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 53 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бат-Эрдэнэ, С.Батболд;
Чөлөөтэй: Б.Баттөмөр, Б.Дэлгэрсайхан, Ц.Сэргэлэн;
Эмнэлгийн чөлөөтэй: Г.Амартүвшин, Д.Ганбат.

Нэг.Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын “Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Замын ашиглалт, засварын хэлтсийн дарга Ц.Эрдэнэ-Очир, мөн яамны Авто замын бодлого, зохицуулалтын газрын ахлах шинжээч Л.Баянзул, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгө, удирдлагын хэлтсийн дарга С.Тулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Д.Нямбаяр, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хуулийн төслийн талаар Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Наранбаатар нарын тавьсан асуултад Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Замын ашиглалт, засварын хэлтсийн дарга Ц.Эрдэнэ-Очир, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгө, удирдлагын хэлтсийн дарга С.Тулга нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Н.Энхболд нар үг хэлэв.

Б.Энх-Амгалан: Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын “Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцид 2016, 2018 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, мөн яамны Далай ашиглалт, усан замын тээврийн хэлтсийн дарга Д.Жавхлан, Далайн захиргааны газрын дарга Д.Отгонсүрэн, мөн газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Ю.Өлзийжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Д.Нямбаяр, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хуулийн төслийн талаар Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Х.Баделхан нарын тавьсан асуултад Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Далай ашиглалт, усан замын тээврийн хэлтсийн дарга Д.Жавхлан, Далайн захиргааны газрын дарга Д.Отгонсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, С.Бямбацогт, Б.Энх-Амгалан нар үг хэлэв.

Б.Энх-Амгалан: Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцид 2016, 2018 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан “Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Энх-Амгалан: “Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /“Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Энх-Амгалан: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 54 минут үргэлжилж, 17 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 58.8 хувийн ирцтэйгээр 11 цаг 47 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 12 дугаар сарын 12-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
10 цаг 53 минут.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Энх-Амгалан: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Бямбасүрэнгийн Энх-Амгалан ирсэн, Норовын Алтанхуяг ирсэн, Ганибалын Амартүвшин гишүүн өвчтэй, Пүрэв-Очирын Анужин гишүүн ирсэн, Хавдисламын Баделхан ирсэн, Энхтайваны Бат-Амгалан ирсэн, Багаагийн Баттөмөр чөлөөтэй, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гадаад томилолттой, Сүхбаатарын Батболд гадаад томилолттой, Дашидондогийн Ганбат өвчтэй, Борхүүгийн Дэлгэрсайхан орон нутгийн томилолттой, Нанзадын Наранбаатар ирсэн, Салдангийн Одонтуяа ирсэн, Цэдэвийн Сэргэлэн гишүүн өвчтэй, Дамдины Цогтбаатар гишүүн ирсэн, Нямаагийн Энхболд гишүүн ирсэн, Жаргалтулгын Эрдэнэбат гишүүн чөлөөтэй. Гишүүдийн ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. Хэлэлцэх асуудал 1.Монгол Улс Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын Монгол Улсын тээврийн

холболт болон логистикийг сайжруулах төслийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл, Засгийн газар 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн. 2.Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцод 2016, 2018 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл, Засгийн газар 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн. 3.Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 12 дугаар сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл. 4.Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудлаа баталлаа. Монгол Улсын нэгдэн орох 2 зээлийн хэлэлцээр байгаа. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын “Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Эхний асуудал Монгол Улс Дэлхийн банкны Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төслийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ. Хуулийн төслийг ажлын хэсгийг танилцуулъя. Сандагийн Бямбацогт Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд, Солонгын Тулга Сангийн яамны Санхүү бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн даргын үүргийг

түр орлон гүйцэтгэгч, Санхүүгийн хөрөнгө удирдлагын хэлтсийн дарга, Цэвээний Эрдэнэ-Очир ЗТХЯ-ны Замын ашиглалт, засварын хэлтсийн дарга, Лувсандонхойн Баянзул ЗТХЯ-ны Авто замын бодлого, зохицуулалтын газрын ахлах шинжээч ийм бүрэлдэхүүн ирсэн байна.

Монгол Улс Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төслийн зээлийн хэлэлцээрийн төслийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа тус тус хэлэлцэж, санал ирүүлсэн. Санал дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд ирүүлсэн. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2022 оны 12 дугаар сарын 19, 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж уг төслийг зөвшилцсөн талаарх санал, дүгнэлтээ ЗГ-т хүргүүлсэн болно. Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ЗГ-ын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт танилцуулна. Бямбацогт сайдын микрофоныг өгье.

С.Бямбацогт: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая. Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон олон улсын хөгжлийн ассоциацитай хамтран хэрэгжүүлэх Монгол Улсын тээврийн холболт болон логистик сайжруулах төслийн зээлийн хэлэлцээрт Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 1 дүгээр захирамжийг үндэслэн 2023 оны 8 дугаар сарын 28-ны өдөр гарын үсэг зурсан. Энэхүү төслийн зорилго нь Монгол Улсын хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлсийн нэг болж буй авто замын дэд бүтцийг сэргээн сайжруулах, улмаар улсын тогтвортой хөгжлийн тулгуур болох хөдөө аж ахуй, түүний дотор мал аж ахуйн бүтээгдэхүүний тээвэр

логистикийн үйл ажиллагааг дэмжихэд чиглэгдсэн болно.

Төслийн хүрээнд нийслэл хотыг баруун бүс, зүүн бүс болон хойд бүс нутагтай холбосон улсын чанартай авто замын сүлжээ дэх нийт 361км хатуу хучилттай авто зам, 8 байршил дахь нийт 1205 метр урт метр төмөр бетон гүүрийг шинэчлэн сайжруулах, ЗГ-ын 2020-оос 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан нутгийн зам төслийн хүрээнд хэрэгжих зарим сумдыг холбох зэрэг ажлууд хийгдэнэ. Энэхүү төсөл нь улсын чанартай гол авто замын сүлжээний насжилт өндөртэй ашиглалтын бэлэн байдлын түвшний үзүүлэлт буурсан Улаанбаатар-Арвайхээр, Арвайхээр-Баянхонгор, Хархорин-Цэцэрлэг, Цэцэрлэг-Тосонцэнгэл, Улаанбаатар-Өндөрхаан, Өндөрхаан-Чойбалсан, Булган-Мөрөн чиглэлийн замын хэсгүүд болон тус чиглэл дагуух Хэрлэн, Орхон, Тамир, Гичхэн, Хануй, Бэлх, Лүн, Түргэн зэрэг голуудын төмөр бетон гүүрнүүдийг хамарч байгаа ба төсөл хэрэгжсэнээр авто замын сүлжээний аюул осолгүй, аятай тухтай, үр ашигтай зорчих нөхцөл эрс дээшилж, тээвэр ашиглалтын зардал буурах, цаг хугацаа хэмнэх, цаашилаад сүлжээний эдийн үр өгөөжийг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой юм.

Төслийг Дэлхийн банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкнаас олгох 100 сая доллар, Олон улсын хөгжлийн ассоциацид олгох 7,3 сая зээлжих тусгай эрх буюу нийт 110 сая ам.долларын санхүүжилтээр хэрэгжүүлнэ. Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь хэсэгт гадаад улс, ОУБ, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаарх олон улсын гэрээ нь Улсын Их Хурлаар заавал соёрхон батлуулах олон улсын гэрээ гэж заасан байдаг. Үүний дагуу тус зээлийн хэлэлцээрийг соёрхон баталж өгөхийг та

бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энх-Амгалан: Бямбацогт сайдад баярлалаа. Энэ зээлийн хэлэлцээр болбол бас өмнө нь Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэгдээд, зөвшилцөх эсэх асуудал энэ манай Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд саналаа ирүүлсэн байгаа. Эдгээр саналуудыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо нэгтгээд, яагаад гэвэл ЗГ-ын гишүүдийн байр суурь нэг байгаагүй, 2 ч удаа буцсан. Тэгээд энэ дээр гишүүд 3 Байнгын хорооноос ирүүлсэн саналуудыг гишүүд энд үзэж, манай Байнгын хороон дээр нэгтгээд, ЗГ-т санал, дүгнэлтээ хүргүүлсэн.

Би энэ санал, дүгнэлтийн 9 санал, дүгнэлт хүргүүлсэн байгаа. Тэгээд энийг засаж янзалж оруулж ир гэж хүргүүлсэн. Тэрийг би уншиж өгье. 1.Энэ төсөл нь тээвэр логистикийн дэд бүтцийн сүлжээг сайжруулан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээний алдагдлыг бууруулж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэнэ гэсэн боловч эдийн засгийн үр ашгийн шалгуур тооцоо, судалгаа үнэлгээг нарийвчлан гаргаагүй байгааг анхаарах. 2.Эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх үүднээс шинэчлэх, засвар хийх улсын чанартай 311км авто замын 1км замын болон засвар хийх 8 бетон гүүрний үнэ өртгийг нарийвчлан гаргаж тооцох. Авто замыг олон улсын болон бүсийн тээвэр логистикийн нэгдсэн сүлжээ баруун болон зүүн босоо тэнхлэгийн авто зам, хөрш орнуудын сүлжээтэй холбоход анхаарах. 3.Жишиг логистикийн төвийг байгуулах, боомтын нэвтрэх чадварыг сайжруулах, гадаад худалдааг нэмэгдүүлэх ажлын хүрээнд автомашины жин хэмжүүр, ариутгалын болон холбогдох тоног төхөөрөмжийг шинэчлэх, сайжруулах ажлыг цогц байдлаар шийдвэрлэх. 4.Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр, жишиг логистикийн төвөө барих хамгийн тохиромжтой, боломжтой газрыг

оновчтой зөв тогтоох, асуудлаа холбогдох яамтай тохирч Засгийн газрын хуралдаанаараа нэг мөр шийдвэрлэх. 5.Бүс нутгийн логистикийн жишиг төвийн техникийн зураг төсөл, техник, эдийн засгийн үзүүлэлт нь зөвшилцөхөөр ирүүлсэн төсөлд байхгүй байгаа нь эдгээр баримт бичиг хийгдсэн эсэх нь тодорхойгүй болохыг анхаарах. 6.Төсөлд эмэгтэй малчдыг платформын үйл ажиллагаанд оролцох цахим хэрэгсэл, ур чадвар, мэдлэгээр дэмжих сургалт гэснийг хасах.

7.Төслийн гэрээний албан ёсны орчуулга бүрэн хийгдээгүй байна. Тухайлбал гэрээний хуваарь 2А-д заасан хүснэгтийн ангилал нэгийн хүрээнд зээлийн хуваарилсан хэмжээ болох 7,3 сая ам.долларыг Монгол хэлэнд орчуулсан албан ёсны орчуулга дурдалгүй орхигдуулсан байгааг анхаарах. Энэ нөгөө Нямаагийн Энхболд гишүүний гаргаж байсан санал тухайн үед. 8.Зээлийн төслийг тогтвортой Төвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан ЗГ-ын өрийн тухай, төсвийн тухай шаардлагад нийцүүлээд нэг ам.доллартой харьцах төгрөгийн хани 3462 төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 21,5 хувиар суларсан. Цаашид ханиийн зөрөөг нэмэгдүүлэх, зөрөө нэмэгдэх хандлагатай байгаа энэ үед уг зээл нь төсөвт дарамт учруулахгүй байхаар шийдвэрлэх. 9.Цаашид Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу ЗГ-ын өрийн тухай, төсвийн тусгай шаардлагад нийцсэн Монгол Улсад үзүүлэх эдийн эдийн засгийн үр ашиг, өгөөжийг сайтар тооцсон зээлийн төслийг Улсын Их Хуралд ирүүлэх талаар анхаарах нь зүйтэй гэсэн байгаа юм. Энэ 9 заалт дээр ямар, ямар арга хэмжээ авсан бэ гэдэг талаар эхлээд нэг товчхон хариулаадах. Тэгээд, асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Энэ 9 асуултад Сандагийн Бямбацогт сайд хариулъя. Бямбацогт сайдын микрофоныг өгье.

С.Бямбацогт: Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хорооноос бас

Эдийн засгийн байнгын хороо болон Төсвийн байнгын хороон дээр хэлэлцэх үеэр гишүүдийн гаргасан, зарим сайд нарын бас гаргасан байр суурьтай холбоотойгоор 9 ийм бас асуудал дээр тодруулга хариулт ирүүл гэсэн шаардлага бидэнд ирүүлсэн байгаа. Ингээд ЗГ-аас бас холбогдох сайд нартайгаа зөвшилцөөд, ЗГ-ын хуралдаанаар дахиж хэлэлцээд таны ирүүлсэн 9 шаардлага дээр тодорхой бас хариултыг хүргүүлсэн. Тэгээд ямар ч байсан болбол бас 9 асуудал үндсэндээ ишийдэгдсэн гэж ойлгож болно.

Тухайлбал та бас хэлж байгаа тэр Өвөрхангай аймагт жишиг логистикийн төв байгуулахаар төлөвлөсөн байсан. Энэ нь эдийн засгийн үр ашиг муутай байна, хувийн хэвшил хийж хэрэгжүүлэх бололцоотой гэдэг асуудлаар Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо хэлэлцэх үеэр болбол гишүүд нэлээн шүүмжилж ярьж байсан. Зарим сайд нарын ч байр суурь ийм байсан. Үүнтэй холбоотойгоор энийг бол хассан. Үүний оронд үндсэндээ хамгийн том тулгамдсан зам, эвдэрсэн зам болох Дорнод, Хэнтий аймгийн дунд байдаг Тамын 50 гэж нэрлэгдсэн энэ 50км зам, цаашилаад тэр Хансунь замын барьсан 27км зам зэрэг замуудыг бас барьж байгуулах нь зүйтэй юм. Энэ бас логистикийн төв буюу махны агуулах худалдааны тэр байрыг болбол үндсэндээ хувийн хэвшлийнхэн хийж хэрэгжүүлэх бололцоотой учраас түүнийг санхүүжүүлэхгүй. Энэ тулгамдсан тэр Дорнодын тамын 50-ийг санхүүжүүлэх байдлаар зохицуулалт хийхээр ингэж бас оруулж ирсэн байгаа.

Мөн бас энэ улсын, 2 дахь асуудал эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх үүднээс шинэчлэх засвар хийх улсын чанартай 310км зам, мөн бас гүүрнүүдийн тооцоо гарга гэсэн. Үүнтэй холбоотойгоор бол өртөг зардлын тооцоонуудыг бүгдийг нь бас нарийвчилж гаргасан байгаа. Энэ хүрээнд бол авто замын их засвар 236км нэгж өртөг нь 293 мянга орчим доллар.

Нийтдээ 70 орчим сая доллар. Авто замын ээлжит засвар 125км үүнийх нь нэгж өртөг нь 110 орчим сая мянган доллар. Нийт 13 сая доллар. Гүүрний засвар 1200 метр гүүр нэгж өртөг нь 7400 ам.доллар. Ингээд 8,9 сая доллароор хийж хэрэгжүүлэх, орон нутгийн зам бас байгаа бас энд бас зарим нэг. Энэ дээр 11 орчим сая доллар гэж ингэж тодорхой бас задалж оруулж ирсэн.

Мөн бас жишиг логистикийн төвийг байгуулах, боомтын нэвтрүүлэх чадварыг сайжруулах, гадаад худалдааг нэмэгдүүлэх ажлын хүрээнд автомашины жин хэмжүүр, ариутгалын болон холбогдох тоног төхөөрөмжийн шинэчлэх сайжруулах ажлыг цогц байдлаар шийдвэрлэ гэсэн асуудлаар бол шаардлага тавьсан. Энд бас хилийн үр бүтээмжийг сайжруулах, тогтвортой худалдааг дэмжих төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа. Энэ хүрээнд бас төслийг хэрэгжүүлснээр Булган, Хавирга, Цагаан нуур зэрэг боомтуудын хилийн үйлчилгээг сайжруулах боомтын, энэ зам замуудаар бас гадаад худалдааг хөнгөвчлөх, бараа эргэлтийг нэмэгдүүлэхэд түлхэц үзүүлэх, зардлыг бууруулахад ач холбогдолтой гэж эхний ээлжид хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байгаа.

Мөн бас зөвлөмжид эмэгтэй малчдыг платформын үйл ажиллагаанд оролцох, цахим хэрэгсэл, ур чадвар, мэдлэгээр дэмжиж сургах гэсэн ийм хэтэрхий юу гэдэг юм деталь ийм шаардлагагүй зүйлс орсон гэсэн ийм бас шүүмжлэлүүд орсон. Үүний дагуу бас үүнийг хасаад, ерөнхийд нь нийтлэгээрээ байх ёстой юм байна гэдэг байдлаар бас оруулсан байгаа.

Мах, мах махан бүтээгдэхүүний үйлдвэр, жишиг логистикийн төвөө барих хамгийн тохиромжтой боломжтой газрыг оновчтой тогтоох, зөв тогтоох асуудлаа холбогдох яамтай нь тохирч, ЗГ-ын хуралдаанаар нэг мөр шийдүүлэх гэсэн бас асуудал оруулж шаардлага тавигдсан байгаа. Гадаад

бодлого, аюулгүй байдлын байнгын хорооноос. Энийг үндсэндээ бол ЗГ-ын хуралдаанаар хэлэлцээд, үндсэндээ энэ одоо бол үүгээр энэ төсөлд хамруулах шаардлагагүй, өөр бусад байдлаар шийдүүлэх бололцоотой гэдэг байгууллагуудаа хассан байгаа.

Төслийн гэрээний албан ёсны орчуулга бүрэн хийгдээгүй байна гэсэн асуудал яригдаж байсан энэтэй холбоотойгоор. Зээлийн хэлэлцээрт бол 2023 оны 8 дугаар сарын 26-ны өдөр гарын үсэг зурсан. Энэ хүрээнд зээл болон санхүүжилтийн хэлэлцээрийг Монгол хэлээр албан ёсоор орчуулгыг хийж хавсаргасан байгаа. Холбогдох бас залруулгуудыг хийсэн гэдгийг танд бас хэлье. Иймэрхүү байдлаар, тэр дараа нь 8, 9 дээр нөгөө Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Засгийн газрын өрийн тухай, төсвийн тухай тусгай шаардлагад нийцүүлэн бас асуудалд бас анхаарах эргэж хар гэсэн шаардлага бас тавигдсан. Үүнтэй холбоотойгоор бас Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.3-д заасны дагуу ЗГ-ын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан харьцаа нь 2023 онд 65 хувь, 2024 онд бас 60 хувиас хэтрэхгүй байхаар хуульчилсан. Үүнтэй холбоотойгоор бас өнөөдөр энэ зээлийг хэрэгжүүлснээр үндсэндээ болбол Засгийн газрын ДНБ-д өрийн, Засгийн газрын өрийн ДНБ эзлэх хувь хэмжээ 2023 онд 44 хувь, 2024 онд 42,7 хувьтай тэнцэхээр тооцоологдсон. Өөрөөр хэлэх юм болбол Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тухай хуулийн төсвийн тусгай шаардлагыг хангахаар ингэж оруулж ирж байгаа гэдгийг танд бас хэлье. Ийм байдлаар үндсэндээ Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хорооноос тавьсан шаардлага, анхаарах асуудлуудыг бид нар биелүүлж, хэрэгжүүлсэн гэдгийг Байнгын хорооны гишүүддээ хэлье.

Б.Энх-Амгалан: Бямбацогт сайдад баярлалаа. 2 юм тодруулаадахъя

Бямбацогт сайдаа. Энэ эсвэл хуваарь дээрээ буруу биччихэв үү эсвэл ийм байна уу? Танилцуулгад бол 311км замын засвар шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэнэ гэж байгаа юм. Тэгээд дэд бүтцийн хөрөнгө оруулалт гэдэг дээрээ энэ хуваарь 1 буюу төслийн танилцуулга дээрээ 361км гээд 50км нэмээд ороод ирсэн байна. Энэ нэмэлт хэлэлцээр хийсэн юм уу эсвэл өөр юмнаасаа хасаад километрийг нь нэмчихсэн юм уу? Энийг нэг хэлж өгөөч 1 дэх асуудал.

2 дахь асуудал Логистикийн үйлчилгээ гээд бүрэлдэхүүн 2 дугаар хэсэг дээр дахиад нөгөө малчид, тэр дундаа эмэгтэй удирдлагатай малчдад платформ-д оролцох цахим хэрэгсэл, ур чадвар, мэдлэгээр дэмжинэ гээд дахиад нөгөө заалт ороод ирчхэж, 2.2 дээр байна. Тэгэхээр зэрэг энэ санаатай орж ирээд байгаа юм уу эсвэл та бол сая болбол энийг ерөнхийд нь явах ёстой. Энэ логистикийн нийлүүлэлтийн сүлжээний платформ болбол нийлүүлэлтийн сүлжээтэйгээ холбогдуулаад ерөнхийдөө явах ёстой, ингээд детальчилж эмэгтэй малчдад хичээл заана гэсэн юм бол байхгүй хасчихсан гэсэн. Энэ дээр бол ингээд ороод ирчихсэн байх юм. Энэний 2-ыг нэг хариулаад өгөөч. Бямбацогт сайдын микрофоныг өгье.

С.Бямбацогт: 311 360км болсон талаар нөгөө Өвөрхангайд махны логистикийн төв байгуулна гэсэн 20 сая доллар төсөвлөж энд оруулж ирсэн байсан. Үүнийг хасаад үндсэндээ энэ 20 сая доллароор түрүүн би хэлсэн Дорнодын тамын 50 буюу Хэнтийгээс Дорнод аймаг чиглэл хийгдэх маш их эвдэрсэн Монгол Улсын 7400км улсын чанартай замаас хамгийн их эвдрэлтэй энэ замыг эхний ээлжид засъя гэж хуваарилсан. Үүнтэй холбоотойгоор 310км зам маань 361 болсон байгаа.

Тэр эмэгтэй малчид гэж онцолсон зүйлийг уул нь хассан. Яагаад дахиад ороод ирсэн эсхүл материал нь өөрт тараагдсан юм болов уу, харин тийм. Энэ дээр энэ дахиад яагаад орчхов, энэ

дээр бас манайхан хариулт байгаа юу?
Эрдэнэ-Очируо, Баянзулаа.

Б.Энх-Амгалан: 2 номерын
микрофон Эрдэнэзуул.

С.Бямбацогт: Уул нь хасахаар
яриад, бид нар хассан шүү дээ.

Б.Энх-Амгалан: Тийм хариул даа
энэ эсвэл алдаатай орчихсон юм уу эсвэл
та нар хэргээр дахин оруулаад ирчихсэн
юм уу? 2 номерын микрофон өгье.

Ц.Эрдэнэ-Очир: Манайхаас бол
хасахаар санал өгсөн. Тэгээд Сангийн
яамнаас бол хасаагүй оруулаад ирсэн юм
болов уу.

Б.Энх-Амгалан: Сангийн яам
хариулах юм уу тэгээд. 1 номерын
микрофон. Энэ дээр бид нар, бид нарт
тарааж өгсөн материалын 2.2 дээр
болбол яг эргээд хэвээрээ байж байна.
Яах вэ нэг өөрчлөгдсөн байна. Тэр нь
эмэгтэй удирдлагатай малчдад гэнэ.
Эмэгтэй удирдлагатай малчид гэж ямар
юм байдаг юм бэ?

С.Тулга: Энийг яаралтай
тодруулаад, Хэрэг эрхлэхээс тодруулаад
эргээд хэлье.

Б.Энх-Амгалан: Үгүй ээ, хас за
юу, тодруулаад байх юм байхгүй. Зүгээр
хас.

С.Тулга: Хасаж өгсөн.

Б.Энх-Амгалан: Тийм. Гишүүд
асуулт асууж, хариулт авч дууслаа.
Н.Наранбаатар гишүүний микрофоныг
өгье. Наранбаатар гишүүн асуултаа
асууя.

Н.Наранбаатар: Та бүхэнд энэ
өглөөний мэнд хүргэе. 24 оны төсөв
батлахад Улаанбаатар Даланзадгад
чиглэлийн замыг энэ Дэлхийн банкны 100
сая долларын зээлийн хүрээнд засварлана
гээд их засвар хийнэ гээд ЗТХЯ-наас ч
мэдэгдэж байсан. Дараа нь төсөв

хэлэлцэх үеэр ч бас энд суусан, ингэж
орсон байгаа. Тэгээд энэ төсөл дээр
байгаа энэ дурдагдсан замууд дотор энэ
байхгүй байх юм. Тэгээд энэ дээр би
тодруулга авах гэсэн юм. Энэ яагаад
хаягдчихав уу, яав? Уг нь төсөв дээр
яригдаад орчихсон байж байгаа шүү дээ,
хууль болоод батлагдчихсан байгаа.

Б.Энх-Амгалан: Наранбаатар
гишүүний асуултад хэн хариулах вэ?
Бямбацогт сайдын микрофоныг өгье.
Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Энэ бас их чухал
зам юм. Даланзадгадаас Мандалговь Төв
аймаг чиглэлд энэ тавьсан зам дээгүүр
үндсэндээ бид нар бас нөгөө даац
хэтрүүлээд мидлинг тээвэрлээд л,
шатахуун тээвэрлээд үндсэндээ энэ зам
бол нэлээн эвдэрсэн байгаа. Энийг засах
гээд бас хөрөнгийн эх үүсвэр нэлээд хайж
байгаа. Монгол Улсын ерөнхий сайд бас
Мандалговь Дундговь аймагт ажиллах
үеэрээ Өмнөговь аймагт ажиллах үеэрээ
бас энэ замыг засна гэдэг асуудлыг бас
илэрхийлсэн. Тэгээд үүнтэй
холбоотойгоор бид нар Сангийн яамтай
нэлээн сайн ярилцсан. Дэлхийн
банкныхантай бас санал солилцож
байгаа. Энэ зээлийн хэлэлцээр
батлагдсаны дараа бас тодорхой
зохицуулалтууд бол хийгээд энэ зам руу
бас тодорхой хуваарилалтуудыг хийж
болох юм гэдэг байдлаар үндсэндээ
болбол ярилцаж ажиллаж байгаа.

Энэ дээр Сангийн яамныхан,
ялангуяа Сангийн яам 2024 оны төсөв
батлах үеэр бас тийм үү улсын төсвийн
хөрөнгө оруулалтаас энэ зам дээр мөнгө
тавьж гэдэг асуудал бид бас ярьсан.
Гэхдээ тухайн үед ярьж байгаад энэ
зээлийн хэлэлцээрийг батлах юу
баталсны дараа бас дотор нь
зохицуулалт хийж болох юм гэдэг
агуулгаар үндсэндээ Сангийн яамныхан
нэлээн хариуцаж ажиллаж гэдэг
байдлаар шийдсэн байгаа. Тийм болохоор
үндсэн зээлийн хэлэлцээр батлагдсаны
дараа болбол зохицуулалт хийж, энэ бас
дотор нь гүйлгэх ийм байдлаар энэ

ажлыг шийдэхээр төлөвлөж байгаа гэдгийг танд хэлье. Энэ гарцаа байхгүй бас анхаарах ёстой, засах ёстой ийм зам байгаа, ойлгож байгаа.

Б.Энх-Амгалан: Бямбацогт сайдад баярлалаа. Наадах чинь болбол 2019 онд 18 онд 7,4 тэрбум, 19 онд 9,7 тэрбум төгрөгөөр засвар хийсэн юм байна лээ. Яагаад гэхээр энэ чинь нөгөө мидлинг, хүнд даацын машинууд явах ЗГ-ын тогтоолтой. Тэрнээсээ болоод эвдрээд байгаа. Тэгээд яах вэ ЗТЯ үе үеийнхээ сайдын үед сайд нарын үед бас 2 дахь гарцыг гаргая гэж Таван толгой Чойр чиглэлийн замыг улсын чанартай зам болгосон. Түүн дээр эхний ээлжид болбол концессоор хийх гэж юмнууд явж байгаад тэр нь цуцлагдчихсан. Одоо бол энэ дээрээ бас нэг тийм санхүүжилт та бүхэн маань олбол цаашидаа энэ 2 урсгал чинь болбол бие биеийгээ тэгш аваад явчих ийм бололцоотой юм байна лээ шүү гэдгийг бас энд хэлье. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан санал хэлэх гишүүд байна уу? Наранбаатар гишүүн, Нямаагийн Энхболд гишүүнээр тасаллаа. Наранбаатар гишүүн саналаа хэлье.

Н.Наранбаатар: Энэ төсөл дээр дурдагдсан ээлжит болон их засвар хийх замууд дотор Улаанбаатар, Мандалговь, Даланзадгад гээд оруулчихъя гэсэн саналтай байна. Тэгээд дараа нь ямар ч байсан энэ дээр нэрээрээ тусчхаад явж байхад дараа нь бас эх үүсвэр юмнууд нь болох байх гэсэн ийм бодолтой, саналтай байна.

Б.Энх-Амгалан: Нямаагийн Энхболд гишүүн үгээ хэлье.

Н.Энхболд: Би хэлэлцээрийг дэмжиж байна. Тэр нөгөө өрийн дээд хязгаар дотроо багтчихсан байгаа байдал, ач холбогдлыг нь хараад дэмжиж байгаа юм. Нэг зүйлийг зүгээр тодотгоод хэлчихье гэсэн юм. Урьд нь бид нар ийм гаднын зээлүүдийг авахад Байнгын хороогоор нэг зөвшилцөөд л ийм,

ийм асуудлуудыг засаж янзална шүү. Тэгэхгүй болбол энэ батлахад хэцүү болно гээд чиглэл өгөөд явуулдаг байсан. Яг тэр чиглэлээр өөрчлөлт орж ирдэг тохиолдол бас их ховор байсан. Яг үнэнийг хэлэхэд тийм ээ. Одоо бас бид нар энийг 10, өнгөрсөн оны 12 сард энэ асуудлыг хэлэлцээд тодорхой асуудлуудыг энэ, энэ чиглэлээр анхаарлаа хандуул, боломж байвал зээл олгогч талтайгаа ярьж байгаад эд нарыгаа өөрчил гэсэн. Сая Бямбацогт сайд танилцууллаа. Нэлээд олон зүйлүүдийг Байнгын хороон дээр яригдсаны дагуу буцааж засаад янзлаад чиглэлийг нь өөрчлөөд ингээд ирсэн байна. Би энийг их бас зөв хандлага явж байна уу гэж бодож байгаа. Яагаад гэвэл Байнгын хороогоор ярьдаг, тэгээд дараа нь ерөөсөө цаад тал маань болохгүй байна гээд л ороод ирдэг байсан юм давтагдалгүй харин Монгол Улсын байр суурь ийм байгаа. Зээл өгч байгаа болбол зээл авч байгаа талынхаа санаа бодлыг заавал сонсож байх ёстой гэдэг энэ зүйлээ нэлээн сайн ярьж, хатуу ярьж, тохиролцож, өөрчлөөд ороод ирж байгаад нь болбол бас энэ том ахиц гэж бодож байна.

Цаашидаа ч гэсэн ийм байх ёстой. Бид нар Байнгын хорооноос нэгэнт л чиглэл өгсөн болбол эргээд эцэслэн батлахаар оруулж ирэх үед нь нөгөөдхийнхөө хариуг авал сонсдог, үгүй ээ болохгүй л бол зээлийг авахгүй ч байж болно шүү дээ. Тийм ээ. Энэ, энэ байдлуудад ахиц гарч байгаад би баяртай байна. Тэгээд дэмжиж байна. Түүрүүн Бямбацогт сайд бас их тодорхой замуудаа хэлчихсэн. Тэрийг хүмүүс сонссон байх гэж бодож байна. Одоо яг түүн дээрээ хүлээгээд байж байгаа. Тэгээд энийг яг энэ гэрээнд дурдсан, хэрэв бололцоотой болбол Наранбаатар гишүүний тэр нэрийг нь оруулчихад бас болохгүй юм байхгүй болов уу. Нэгэнт сайд тэгэж хэлж байна, Сангийн яам энэ тал дээрээ ярилцсан юм байна. Ингээж тавьж байгаад, тэгээд энэ дотроосоо хөрөнгө мөнгө гаргаад илүү дутуу хэмнэгдсэн элдэв юу байх нь уу. Тэгвэл энэ

урд талын замыг янзлахгүй бол нээрээ урагшаа Төв аймгаас жаахан яваад л, Дундговь өнгөрөөд л, тэгээд л тэр зам бол явахын аргагүй болчихсон. Ноднин зун би явж үзсэн. Тэгээд үнэхээр хэцүү болчихсон юм байна лээ. Уг нь шинэ зам шүү дээ тийм ээ, уг нь шинэхэн зам шүү дээ. Тэгсэн мөртөө маш хэцүү болсон байна лээ. Тэгэхээр энийг бас оруулаад, тэгээд дундаас нь бололцоо гаргах тал дээр нь ЗГ хэрэгжүүлж байгаа байгууллагууд анхаарах нь зүйтэй байх гэж бодож байна.

Б.Энх-Амгалан: Энхболд гишүүнд баярлалаа. Гишүүд уг хэлж дууслаа. Санал хураалт явуулна. Санал хураалтын өмнө 2 юм анхаараадахъя. Энэ нөгөө малчин эмэгтэйчүүдийн платформыг сургалтыг дэмжинэ гэсэн юм хасагдахаар боллоо шүү, протоколд тийм ээ. Хасагдахаар болсон биз, үгүй юм уу? Тэгсэн тийм ээ? Сайд хасагдахаар болсон гэдгээ хэллээ шүү. 2 дахь нь тэр сайд бас өөрөө хэлж байх шиг байна. Тэр Даланзадгадын чиглэлийн замыг энэ дотроо бас хэлэлцээр дотор оруулна гэдэг юмыг протоколд тусгаад, тэгээд санал хураалт явуулъя. Монгол Улс Дэлхийн банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төслийн зээлийн хэлэлцээрийг Соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүдээ. Санал хураалтын дүнг танилцуулъя. 10 гишүүн хуралдаанд оролцож, 6 гишүүн дэмжиж 60 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Энхболд гишүүн та танилцуулах уу? Нямаагийн Энхболд гишүүн танилцуулна. Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

11.18 цаг

Хоёр.Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцид 2016, 2018 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

2 дугаар асуудал Олон улсын хөдөлмөрийн байгууллагын далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцид 2016, 2018 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцье. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Сандагийн Бямбацогт Улсын Их Хурлын гишүүн, ЗГ-ын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд, Дагвын Жавхлан ЗТХЯ-ны Далай ашиглалт, усан замын тээврийн хэлтсийн дарга, Сүхээгийн Мяндасмаа ЗТХЯ-ны Хуулийн хэлтсийн дарга, Дамдинсүрэнгийн Отгонсүрэн Далайн захиргааны газрын дарга, Юрагийн Өлзийжаргал Далайн захиргааны Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга. Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, ЗГ-ын гишүүн, Зам тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт танилцуулна. Бямбацогт сайдын микрофоныг өгье.

С.Бямбацогт: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийнхээ өглөөний амгаланг дахин айлтгая. Тэгээд Монгол Улс нь Олон улсын хөдөлмөрийн байгууллагын гишүүнээр 1968 онд элсэн орсон байдаг. Тус байгууллагын Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцид 2014 онд нэгдэн орсныг, мөн энэхүү конвенцид 2014 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Монгол Улсын Их Хурал 2019 онд тус тус соёрхон баталсан. Швейцар улсын нийслэл Женев хотноо 2016, 2018 онуудад зохион байгуулагдсан Олон улсын хөдөлмөрийн байгууллагын бага хурлаар тус конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулсан нь 2019 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр болон 2020 оны 12

дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн тус тус хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн. Одоогоор нийт 90 гаруй улс энэхүү нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөөд байна. Энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр далайчдын эрхийг хамгаалах үүднээс хөлөг онгоц дээрх ялгаварлал гадуурхалт болон дарамтыг багасгах мөн далайн дээрэм болон хөлөг онгоцны эсрэг зэвсэглэсэн дээрэм тонуул гэсэн нэр томъёог шинээр тусгаж тус нөхцөл байдлын улмаас олзлогдсон үеийн далайчны хөдөлмөрийн гэрээний зохицуулалтыг нэмсэн болно.

Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцод 2016, 2018 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт соёрхон баталснаар Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоц дээр ажиллаж буй далайчны хөдөлмөрлөх эрхийг хангах, хөлөг онгоц эзэмшигчийн зүгээс далайчинтай байгуулсан хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн хариуцлагыг өндөржүүлж ач холбогдолтой юм. Иймд олон улсын гэрээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцод 2016, 2018 оны оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг танилцуулж байна. Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энх-Амгалан: Бямбацогт сайдад баярлалаа. Энэ зөвшилцөхөөр орж ирж байгаа энэ олон улсын хөдөлмөрийн байгууллагын Далайн хөдөлмөрийн тухай хуулийн 2006 оны конвенцод 2016, 2018 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хуралд шууд зөвшилцөх, хэлэлцүүлэхээр ирүүлж байгаа юм. Нэг ёсондоо энэ болбол нөгөө зөвшилцөх, хэлэлцэх нь хамтдаа явж байгаа юм шүү гэдгийг бас энд хэлье. Ингээд хэлэлцэж

байгаа асуудалтай холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү. Баделхан гишүүнээр тасаллаа. Нямаагийн Энхболд гишүүн асуултаа асууя.

Н.Энхболд: Яг өнөөдрийн байдлаар манай далбаатай хэдэн онгоц байна вэ? Тэн дээр яг хэдэн далайчин байгаа вэ? 1 дүгээр асуудал. Энэ юуг хараад үзэхээр энэ бас нэлээн болгоомжтой хандахгүй бол хэн, юу хариуцахаа их ойлголцохгүй болбол сонин заалтууд байдаг юм байна. Энэ нийтлэг л юм л даа. Тэгэхдээ бид нар бас нэг ойлголттой байх нь зөв болов уу гэж бодож байна. Жишээ нь гишүүн улс бүр далайчны хөдөлмөрийн гэрээг түүний хүчинтэй хугацаа дууссаныг харгалзахгүйгээр хэрэв ямар нэгэн халдлагад өртсөн байвал тэрийг хүчинтэй хэвээрээ байлгахыг шаардана гэж байгаа юм. Яах вэ бид нар шаардана гэж бодъё. Тэгэхдээ хариуцлагыг нь хэн хүлээх вэ? Бид шаардаад, хүчинтэй гэж үлдчихээд, өөрөө нэгэнт хүчинтэйгээрээ байгаа юм чинь хариуцлагыг нь бид нар хүлээх, хүлээнэ гэж хандах нь зөв үү буруу юу? Эсхүл өөр хэн нэгэн этгээд хариуцах уу? Ер нь урьд нь манай далбаатай онгоц дээр яг ийм тохиолдлууд гарч байсан зүйл байна уу? Далайн дээрэмчдийн халдлагад өртсөн тийм ээ, бусад энд заачихсан байгаа хүчирхийллийн аливаа халдлагад өртсөн ийм тохиолдлууд бий юү? Тэр тохиолдолд манай далбааг хэрэглээд онгоц ашиглаж байгаа улс нь энэ хариуцлагыг нь хүлээж байсан уу? Манайд ямар нэгэн хариуцлага бас хүлээх тохиолдол гарч байсан уу?

Бүүр тодруулаад асуувал энэ чинь бас нэлээд их гараад байгаа үзэгдэл шүү дээ. Зүүн өмнөд Азийн чиглэл, Зүүн Хятад, Хятадын урд талын тэнгисүүд, тэр Судан, Сомали тийм ээ, тэр хавиар чинь бас далайн дээрэмчид нэлээн их идэвхтэй байдаг. Тэгээд барьцаалаад мөнгө нэхсэн тохиолдолд хэн төлөх вэ? Далбаагаа ашиглуулж байгаа манай улс төлөх үү? Манай далбааг ашиглаад явж

байгаа тэр хуулийн этгээдүүд нь төлөх үү? Энэ юмнуудыг нэг тодруулъя.

Б.Энх-Амгалан: Хэн хариулах вэ? Гараа өргөчих, 2 номерын микрофон.

Н.Энхболд: Би ганцхан асуулт дээрээ нэг зүйл нэмээдэхье даргаа. Одоо жишээ нь ингэж байгаа юм. Аливаа мөнгийг гуйвуулах зэрэг түүний цалин хөлс бусад эрхийг олзлогдсон бүх хугацаанд түүнчлэн суллагаад эх орондоо буцах хүртэлх хугацаанд эсхүл нөгөө олзлогдсон үедээ нас барсан бол холбогдох дотоодын хууль тогтоомж журмын дагуу нас барсан өдрийг тодорхойлох хүртэлх хугацаанд үргэлжлүүлэн ийм төлбөрөө төлөх юм байна. Тэгэхээр энэ дотоодын хууль тогтоомж гэдэг юм нь манайд хамаарч байна уу эсхүл далбаа ашиглаад явж байгаа тэр улсад нь хамаарч байна уу гэх мэтчилэн зүйлүүдийн нэг тодорхой ойлголт өгөөч бид нарт.

Б.Энх-Амгалан: Маш тодорхой 2 асуулт асуулаа шүү. 2 номерын микрофон, өөрийгөө танилцуулаад тэгээд хариулъя. 2 номерын микрофоныг өгье.

Д.Отгонсүрэн: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Энхболд гишүүний асуултад хариулъя. Яг өнөөдрийн байдлаар 26 улсын 281 хөлөг онгоц Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй, их далайд хөвж явж байна. Энэ дээр нийтдээ 650, 51 орчим яг далайчин манай байгууллагаас гэрчилгээ аваад энэ дээр ажиллаж байгаа. 2 дугаарт энэ яг энэ далайн дээрэмд өртсөн гэдэг талаар асууж байна. БНСУ-ын Хон Сан Сун гэдэг хөлөг онгоц 2010 онд оны 4 дүгээр сард энэ Оманы эрэг орчмоор явж байгаад дээрэмчдэд барьцаалагдаад ингээд 2011 оны 1 дүгээр сард барьцаанд байж байгаад чөлөөлөгдөж онгоцыг нь авсан байдаг. Энэ дээр нийтдээ БНСУ-ын эзэмшигч компаниас барьцаалагчид 10 сая доллар нэхэж, БНСУ-ын талаас 4 сая төгрөгийг, 4 сая долларыг өгч онгоцоо

чөлөөлж авсан байдаг. Хөлөг онгоц дээр энэ аливаа хариуцлага энэ дээрэмтэй холбоотой аливаа хариуцлагыг яг эцсийн хариуцагчаар хөлөг онгоц эзэмшигч хариуцахаар ингэж байгаа конвенцод.

Б.Энх-Амгалан: Дотоодын хууль тогтоомж гэдгээ нэмээд хариулаадах, 2 номер эсвэл тэнд хэд байна вэ? 3 номер дээр. Мяндасмаа хариулах гэж байна уу? Хэн нь хариулах гэж байна вэ? 3 номерын микрофоныг өг дөө. Энэ талдаа, энэ талдаа суугаад, өөрийгөө танилцуулаад тэгээд хариулаарай.

Д.Жавхлан: Жавхлан ЗТХЯ-ны хэлтсийн дарга. Далайн дээрэм гэдэг маань өөрөө манай энэ НҮБ-ын Далайн эрх зүйн конвенцод 82 оны конвенцод заасан утгатай адилхнаар хэрэглэдэг. Энэ тохиолдолд далайн дээрэмд өртсөн тохиолдолд хөдөлмөрийн гэрээ болон хамтын гэрээ эсхүл үндэсний хууль тогтоомжийн дагуу гэсэн орсны дагуу бол түүний цалин хөлс болон бусад төлбөрийг нь зөвхөн хөлөг онгоц эзэмшигч бүрэн төлөх зохицуулалтыг нь конвенцоор оруулж өгч байгаа юм. Зөвхөн хөлөг онгоц эзэмшигч хариуцахаар.

Б.Энх-Амгалан: Тэгэхээр болбол манай далбааг ашигласан болбол тэр далбааны эзэн улс биш хөлөг онгоц эзэмшигч бүх төлбөрийг хариуцна гэсэн үг тийм үү? Баярлалаа. Баделхан гишүүн асуултаа асууя. Баделхан гишүүний микрофоныг өгье.

Х.Баделхан: Баярлалаа. Нийтдээ 281 хөлөг онгоц бүртгэлтэй байна гэж сая хариуллаа. Бид ер нь энэ хөлөг онгоцноос юуг нь хариуцдаг юм, ямар хяналт тавьдаг юм, тэгээд эндээсээ бидний манай улсад кармад ордог юм байна уу ер нь? Ер нь далайн захиргааны байгууллага гэж байгууллага байгаа юм байна. Энэ болбол хэчнээн орон тоотой, хэчнээн бүтэцтэй, ер нь жилийн төсөв нь улсын төсвөөс санхүүжиж байгаа, хэр төсөвтэй байдаг юм бол? Тэгээд ер нь энэ байгууллага ер нь улсын төсөвт

хэр хэмжээний орлого оруулдаг юм бэ? Бид ер нь энэ хөлөг онгоц бүртгээж аваад, далбаагаа ашиглуулаад, тэгээд хэр хэмжээний зарлага гаргаад, нэг ёсондоо хэр хэмжээний жилдээ орлого олдог юм бэ гэсэн ийм асуулт байна. Баярлалаа.

Б.Энх-Амгалан: Хэн хариулах вэ? Далайн захиргааны газрын дарга Отгонсүрэн хариулах уу? 2 номерын микрофон өгье. Тодорхой хариулаарай. Баделхан гишүүний асуултад хариулъя.

Д.Отгонсүрэн: Гишүүний асуултад хариулъя. Хөлөг онгоцоо бүртгэх, бүртгээгүй, бүртгэсэн хөлөг онгоцыг хяналт хийх энэ асуудлыг Монгол Улсын далайн захиргаа хариуцаж явж байгаа. Энэ дээр нийтдээ 31 олон улсын конвенц, протоколуудад Монгол Улс нэгдэж орсон байдаг. Энэ хүрээндээ Далай ашиглах тухай хууль бас энэ хүрээнд хэрэгжилтийг хангаад ажилладаг. Далайн захиргааны хувьд нийт орон тоо нь 31 орон тоотой. Энэ дээр Далай ашиглах тухай хууль, Усан замын тээврийн тухай хууль болоод энэ олон улсын гэрээ, конвенц, хуурай боомтын асуудлуудыг хариуцаж ингээж үйл ажиллагаагаа явуулдаг.

2021 оны 3 сараас хойш энэ Улаанбаатар хотод энэ хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааг яг бие дааж Монгол Улс эндээ хариуцаж хийж байгаа. Энэ дээрээсээ нийтдээ яг өнөөдрийн байдлаар энэ оны хувьд, өнгөрсөн онд бол нэг орчим сая 1 сая долларын орлого олсон бол хөлөг онгоцны бүртгэлээс энэ жилийн хувьд 1,2 сая ам.долларын орлогыг олоод байна. Нийтдээ 250 сая төгрөгийг бас энэ 2023 онд улсын төсөвт төвлөрүүлж байгаа. Ирэх оны төсөвт 300 сая төгрөг төвлөрүүлэхээр ингээд явж байгаа. Нийтдээ урсгал зардлын хувьд бол 3,6 орчим тэрбумыг нь 2023 онд төлөвлөөд хэрэгжүүлээд явж байгаа. Энэ дээр бас ажилчдын цалин хөлс, мөн дотоодын усан замын тээврийн хэрэгслийн бүртгэл хяналт, мөн энэ хуурай боомт, далайн тээврийн, далайн боомтуудын асуудал

хариуцаад энэ хүрээндээ ажлууддаа зарцуулаад явдаг байгаа.

Б.Энх-Амгалан: Нэмэлт хариултыг Бямбацогт сайд өгье. Бямбацогт сайдын микрофоныг өгье.

С.Бямбацогт: Тэгээд урьд нь болбол далайн захиргаа Синганур улсад байрлаад тэнд оффистой, тэнд үйл ажиллагаа явуулдаг байсан юм байна лээ. Одоо бол үндсэндээ Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа, илүү, дутуу зардал гарах ер нь багассан. Зөвхөн түрүүний хэлдэг гучаад улсын 280-аад хөлөг онгоцыг бүртгээд, хяналт тавиад түүнээсээ хураамж авч, түүнийхээ орлогоор санхүүжээд, түүнээсээ илүү гарсныгаа улсын төсөвт төвлөрүүлдэг ийм л зарчмаар ажилладаг, ийм чиг үүрэгтэй байсан. Одоо энэ чиг үүрэг нь хэвээрээ. Энэ дээр нэмээд бид нар хуурай боомтын асуудал. Монгол Улс үндсэндээ хуурай 6 боомттой болох гэж байгаа. Энэ Замын-Үүд-Улаанбаатар Сайншанд, баруун талдаа Ховд, зүүн талдаа Дорнод гээд энэ хуурай боомтуудыг үндсэндээ бас хөгжүүлэх, хуурай боомтуудыг байгуулах энэ тал дээр бас далайн захиргааны бас үндсэн нэг чиг үүрэг болгож, үйл ажиллагааг нь өргөтгөж өгсөн. Одоо энэ асуудлыг хариуцаж байна. Мөн дээрээс нь Монгол Улсад байж байгаа, үйл ажиллагаа явуулж байгаа нуур, томоохон голууд, нуурууд дээр үйл ажиллагаа явуулж байгаа энэ усан завь, энэ хөлөг онгоц энэ.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: Гүйцээгээд хариулчихъя, нэмж микрофон өгье. Бямбацогт сайдын микрофоныг.

С.Бямбацогт: Хөвсгөл нуураас авхуулаад олон нуурууд дээр бас аялал жуулчлал хөгжсөнтэй холбоотойгоор усан онгоц, усан завинууд бас үйл ажиллагаа явуулдаг шүү дээ зун ялангуяа. Тэгээд энэ үед үндсэндээ үүнтэй холбоотой аюулгүй ажиллагааг хангах бас хяналт тавих, бүртгэх энэ Монгол Улс дахь нуур цөөрмүүд дээр үйл

ажиллагаа явуулж байгаа энэ усан завинуудын бас зохицуулалтыг хийх ажлыг болбол бас манай сургалтаас авхуулаад бүгдийг нь бол Далайн захиргааны газар хариуцдаг, хуурай боомт, далайн захиргааны газрын газар. Ийм байдлаар үндсэндээ үйл ажиллагааных нь цар хүрээ бас өдрөөс өдөрт бас өргөжиж байгаа. Ер нь дэлхийд нөгөө далайд гарцгүй мөртөө 2 том хөрштэй мөртөө бас ингээд далайд усан онгоц аялуулаад бас түүнээсээ орлого олоод явж байгаа сайн жишгээс чинь бас суралцъя. Бид бас ингэх бололцоотой болов уу гээд бас Монгол Улсын Ерөнхий сайдыг Киргиз улсад бас өнгөрсөн намар айлчилж байх үеэр бас Киргизүүд бас нэлээн асууж байна лээ. Тийм болохоор бид нар бас үндсэндээ бүр далайд гарцгүй мөртөө ингээд далайд бас хөлөг онгоц аялуулаад бас бүртгэлтэй түүнээс бас бага зэргийн ч гэсэн орлого олж байгаа нь бол бас бидний бас дэлхийд бас тийм сайн жишиг болж байгаа юм байна гэж харсан.

Цаашидаа бид нар хуурай боомт, Тяньжин дээр ачаа бараа гацаж байгаа. Тэр ачаа бараа гацаж байгаа ачааг тийм үү, Тяньжин дээр гацаахгүй шууд Замын-Үүд дээр авдаг байх энэ чиглэл рүү бас манай Далайн захиргаа энэ хуурай боомтын асуудал эрхэлсэн газраа бид нэлээн ажиллуулж байгаа. Цаашидаа ийм байдлаар зөвхөн ганцхан Тяньжин гэсэн боомтоор харьцдаг байсан бол бид нар далайгаар Хятадын 3 Лэ Ин Гуан, Жиньжоу боомтоор бас ачаа бараагаа татдаг болох асуудлыг ярьж байна. Нөгөө талдаа бүүр Энэтхэгийн далай, Иран Бандар-Аббас боомтоор хүртэл нааш нь ачаа бараагаа татах ийм асуудлыг хүртэл судлаад, дээрээс нь зөвхөн тэр боомт, далай дээр ачаа, далайн боомт дээр ачаа гацах биш шууд хуурай боомт дээр ачаагаа авдаг болох энэ чиглэлээр манай далайн захиргаа бол илүү цаашидаа өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулах ёстой, ийм бас шаардлага тавьж ажиллуулж байгаа.

Б.Энх-Амгалан: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хэлэлцэж байгаа хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Нямаагийн Энхболд гишүүнээр тасаллаа. Нямаагийн Энхболд гишүүн үгээ хэлье.

Н.Энхболд: Би энэ конвенцын актад оруулж байгаа энэ нэмэлт, өөрчлөлтийг дэмжиж байна. Хүлээн авах нь зүйтэй байх, хууль гаргаж байгаа. Би зүгээр яг энэ асуудалтай холбоогүй юм. Тэгэхдээ Бямбацогт сайдыг нэг асуудал анхаараасай гэж бодож байгаа юм. Саяхан би нэг ажлаар Голландад очоод Роттердамд очоод ирсэн юм. Тэгээд тэнд Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхимын салбарын нээлтийн ажиллагаанд Лу.Болд Элчин сайдтай хамт оролцсон юм. Тэрэн дээр тэр Голландын талын манайтай хамтарч үйл ажиллагаа явуулдаг, манайд өргөмжит консулаар манайхыг төлөөлөн ажилладаг энэ тэр улсууд нэг санал ярьж байна лээ. Тэр нь юу вэ гэхээр энэ Тяньжинд манай нэг 10 га газар байгаа шүү дээ тийм ээ. Тэрүүнийгээ бид нар ашиглаж чадахгүй их олон жил болж байгаа. Уг нь Хятадын ЗГ-аас манайд хямдхан хямдруулсан үнээр өгөөд, тэгээд энэ дээр та нар боомтоо байгуулаад ашиглаад яваач гэсэн ийм зохицуулалттай юм билээ. Тэгээд тэрийг одоо болтол ингээд ашиглаж чадахгүй яваад байгаа.

Тэрийг тэр жишээ нь Голландууд мэдэж байна. Тэгээд бид болбол дэлхийн хэмжээнд ийм усан боомт дээр ажилладаг нэгжүүдийг төлөвлөдөг, төсөвлөдөг, байгуулдаг, үйл ажиллагааг нь аваад явдаг, менежментийн талаар болбол яг үнэндээ хэлэхэд бол нэгд орно гэж. Роттердамын боомт бол 40км үргэлжилсэн Европын бүх боомтуудын усан боомтуудыг нийлүүлснээс том хүчин чадалтай тийм боомт байдаг гэж өөрснөө танилцуулж, тэгээд бид бол их туршилагатай. Танай тэр газар олгогдчихсон байгаа боомт дээр чинь хамтарч ажиллах боломж бий юу гэсэн

санал тавиад, хэрэв тэгвэл бэлэн шүү, зураг төсвийг нь гаргахаас эхлээд л, цаашидаа хэрэв Монголын тал хүсвэл хамтраад ашиглалт дээр ч гэсэн ажиллаж болох ийм боломж бид нарт бүрэн байгаа гэж тэр Монголтой ажилладаг талын хүмүүс санал болгож байна лээ. Тэрийг та бас нэг.

Би тэгээд энэ Далайн захиргаа одоо Монголын төмөр замд харьяалагдаад явж байгаа юм байна шүү дээ, тийм ээ? Тэд нарын хүмүүстэй уулзаад, одоо болтол тэр газрыг яаж манайд өгсөн, яагаад ашиглахгүй байгаа, ямар асуудлууд байгаа гэдгийг нь товчхон мэдээ аваад Болд сайд руу явуулж байгаа юм. Тэгээд цаад хүмүүстэй танилцуулна биз, цаадуул нь тэгээд яаж харах юм байгаа юм. Зүгээр мэдээж Хятадын тал өөрөө харьцангуй хямдхан үнээр манайд газраа өгч байгаа болохоор бид нар хамтраад ажиллаж гэдэг санал тавих нь болбол бараг ойлгомжтой байх. Зүгээр нөхцөл байдал, үнэ, хамтарч ашиглах болзол юмнуудаа хараад манайд илүү ашигтай гэвэл жишээ нь гуравдагч хөршийн хөрөнгө оруулалт гэдэг талаас нь, тэгээд ер нь турилагатай улс гэдэг талаас нь хамтраад ажиллах боломж байдаг юм биш байгаа гэж бодож л тэр материалуудыг Болдод явуулаад, юу ч гэсэн танилцуулаарай гэж хэлчихсэн байгаа. Хэрэв тэндээс ямар нэгэн хариу ирвэл нөгөө талаас одоо байгаа тэр нөхцөл байдлууд нь яаж шийдэгдэх гээд байгаа юм, тэрийг нь судалж үзээд, бололцоотой болбол тэр асуудлыг бас нэг харж үзээрэй гэж зүгээр санал болгож байгаа юм. Тэгэхдээ та нарын шийдэх асуудал шүү дээ гэхдээ.

Б.Энх-Амгалан: Энэ дээр хэн, Бямбацогт сайд нэг мэдээлэл өгөөч. Бямбацогт сайдын микрофоныг өгье.

С.Бямбацогт: Тийм, маш чухал асуудал хөндөж байгаа юм. Энэ 2006 онд билүү дээ Тяньжин боомт дээр манайх 10 га газартай болсон гэж ярьдаг юм байна лээ. Тэгээд өнгөрсөн хавар 7 сард,

6 сард Ерөнхий сайд Хятад улсад айлчилсан. Энэ үеэр Тяньжин боомт дээр очиж яг тэр газар дээр, боомттой бид нар үйл ажиллагаатай танилцсан. Тэгээд харахад бидний төсөөлөл бидний Монголчуудын ярьдаг ойлголт, бодож байгаа бодол тэр боомтын газрын байршил 2 болбол их зөрөөтэй юм байна лээ. Далайн боомт дээр, яг далайтай залгаа хуурай газар дээр байршилтай байсан болбол тэндээс тийм үү усан онгоцноос ачаа буулгаад л, шууд төмөр зам дээр тавиад л ингээд тээвэрлээд явж байгаа. Гэтэл манайд өгсөн газар маань далайгаас тодорхой зайтай, шууд усан онгоц шууд тийм үү хажууд нь зогсох бололцоогүй. Тийм болохоор тэр усан онгоцноос контейнер, ачаа барааг буулгаад, дахиад автомашинаар тээвэрлээд дахь тэр газар дээр авчраад, тэндээсээ дахиад төмөр замаар Монгол руу татах ийм л нөхцөл байдалтай юм байна лээ л дээ. Тийм утгаараа үндсэндээ бол тэнд ачаа ачиж буулгах терминал боомт байгуулах үндсэндээ бол боломж багатай юм байна лээ.

Гэтэл бид нар яг тэгээд л ойлгочихсон. Ерөөсөө л Монгол руу ирж байгаа ачааг Тяньжинд байгаа 10 га газар дээр хурдан буулгаад л, гялс усан онгоцноос буулгаад л, тэгэнгүүтээ төмөр замаар гялс татаад л, Улаанбаатарт авчрах, тэр газраа ашиглаач, ашигламаар байна шүү дээ гээд. Тэгэхээр ийм мэдээллүүдээ нөгөө тийм үү зөв өгдөггүй, мэдээлэл ойлголтын зөрөө багатайгаас хүмүүс ерөөсөө л далайн эрэг дээр далайтай залгаатай залгаа, усан онгоц шууд ачаагаа буулгах бололцоотой газартай гэж ойлгоод байдаг. Гэтэл тийм биш. Гэхдээ энэ нь юу гэдэг юм энэ газар үр ашиггүй газар биш, газар юм байна гэсэн үг биш бас. Энэ газар дээр бид нар агуулах тийм үү, худалдаа юу байдаг юм ийм чөлөөт бүсийн зориулалтаар ашиглах бүрэн бололцоотой, эргээд тийм бас эдийн засгийн үр өгөөжтэй байх маш том боломж байгаа юм байна лээ бас. Хэдийгээр ачиж, буулгах терминал байгуулахгүй ч гэсэн бид нар энд чөлөөт

бүс байгуулах, агуулах худалдаа хийх тийм үү ийм байдлаар ашиглах маш том боломж байгаа юм байна лээ. Энэ тал дээр МТЗ компанид байнга бас энэ чиглэлээр нь хурдан ажиллуул.

Урьд нь Хятадуудтай ингээд хамтраад 49, 51-тэй компани байгуулчихсан. Тэгэх шаардлагагүй. Энэ төрийн өмчит компани 100 хувь эзэмшээд, энэ дээр өөр илүү үр өгөөжтэй, хурдан хугацаанд ашиглах бололцоотой нөхдүүдтэй ажилла гэсэн чиглэлийг өгөөд ажиллаж байгаа. Ингэхгүй одоо яасан гэвэл бас л нэг 10-аад жилийн өмнө нэг Хятадын компанид 49 хувиа өгчихсөн. Тэд нар нь тодорхой мөнгө гаргачихсан, тэгэнгүүт одоо тэднээсээ салж чадахаа больчихсон. Нөгөөдүүл нь нэмээд хөрөнгө гаргаж чадахгүй, ингээд гацчихсан байдалтай байж байгаа. Тийм болохоор тэд нартай тооцоогоо хурдан дуусгаад, илүү өгөөжтэй, хурдан үйл ажиллагаа явуулж, өгөөжийг нь хүртэх ёстой гэсэн чиглэлийг МТЗ компанид хугацаатай үүрэг өгсөн, ажиллаж байгаа. Хугацаандаа үүргээ биелүүлэхгүй бол бас хариуцлагын асуудал ярина.

Б.Энх-Амгалан: Бямбацогт сайдад баярлалаа. Санал хураана. Санал хураахын өмнө протоколд 2 зүйл тэмдэглүүлээдэхье. Нэг нь болбол яг энэ Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцод 16, 18 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан Соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжихээс гадна, та бүхэн маань яг гадна талд байж байгаа тэр манай далбааг ашиглаж байгаа онгоцнуудыг тэгээд шалгадаг, хөдөлмөрийнх нь хуваарийг үздэг барьдаг ийм юмнуудаа хийхдээ тухайн орны тэр мэргэжлийн хүмүүсийг ашиглаж байгаарай. Тэгэхгүй бол эндээс далайгаа мэдэхгүй, далай байтугай юм үзээгүй нөхөр давхиж очоод шалгаад байдаг. Тэгээд тэр нь хэл усны хувьд ч тэр, Далайн конвенцынхоо хувьд ч тэр, Олон улсын хууль, эрх зүйн хувьд ч тэр бас мэдлэг чадвар нь хүрэхгүй нэг дэмий

аялсан болоод ирдэг нэг ийм юм руу битгий орчхоорой гэдэг нэг дэх ийм санал байгаа юм.

2 дахь нь болбол энэ далайн хуульд нэгэнт ингээд нэмэгдээд орж байгаа ийм үедээ болбол бас дотоодын далайнхаа тээврийн асуудлыг хөгжүүлэх тал дээр нэлээн онцгой анхаарч, цаашидаа бас хуурай боомт явуулах талаар бас нэлээн бодлого барьж байгаа гэж сайд хэлж байна. Энэ чиглэлдээ нэлээн сайн анхаарч ажиллаарай гэдгийг бас та бүхнээс хүсэх байна. Ингээд хуулийн төсөлтэй холбогдуулаад гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцод 2016, 2018 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Хуралдаанд 10 гишүүн оролцож, 6 гишүүн санал дэмжиж, 60 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд танилцуулна. Дараагийн асуудалдаа оръё. Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

11.41 цаг

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

3.Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 12 дугаар сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23.2.14-д эрхлэх асуудлынхаа хүрээнд хуульд заасны дагуу тогтоол гаргах гэж заасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10.6-д энэ хуулийн 10.5-д заасан дарааллын үндэслэн хэлэлцэх асуудлын цаглаврыг Байнгын хороод баталж мөрдүүлнэ. 10.5-д ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлыг баталсан Улсын Их Хурлын тогтоолд заасан хууль тогтоолын төслийн хэлэлцэх дарааллын Зөвлөлийн саналыг харгалзан Улсын Их Хурлын дарга сар бүр захирамжаар батална гэж тус тус заасан.

Тогтоолын төслийг гишүүдэд урьдчилан тараасан байгаа. Би уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 16 дахь хэсгийг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос тогтоох нь.

1. Монгол Улсын Их Хурлын даргын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай 199 дүгээр захирамжид заасан Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэх цаглаврыг хавсралтаар баталсугай.

2. Хэлэлцэх хугацааг хуульд заасан, хуульд тусгайлан заасан болон бусад Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэхэд энэ цаглавар хамаарахгүй.

3. Энэ тогтоолын төслийг төслийн тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо Б.Энх-Амгаланд, хэлэлцэх асуудлын бэлтгэл хангах, мэргэжил арга зүй, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэхийг Улсын Их Хурлын Тамгын газар Д.Энхбатад үүрэг болгосугай. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо гэсэн ийм тогтоолын төсөл байна. Тогтоолын төсөлтэй холбоотой, холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлж, асуулт асууж дууслаа. Санал хураалт явуулъя. Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 12 дугаар сард Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоол тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 60 хувийн саналаар уг санал дэмжигдлээ. Санал хураалтын дүнг танилцууллаа. Тогтоолын төсөл дэмжигдсэнтэй холбогдуулаад дараагийн асуудалд оръё. Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа. Энэ чинь батлах тийм ээ.

11.47 цаг

Дөрөв. “Ажлын хэсэг тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /“Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Дараагийн асуудалдаа оръё. 4. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25.5-д Байнгын хороо шаардлагатай бол хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж, энэ асуудлаар Байнгын хорооны тогтоол гаргана гэж заасан. Энэтэй холбогдуулаад тогтоолын

төслийг гишүүдэд тарааж өгсөн байгаа. Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Ажлын хэсэг байгуулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос тогтоох нь.

1. Монгол Улсын ЗГ-аас 2023 оны 10 сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны болон чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Ажлын хэсгийн ахлагч Б.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, гишүүд Д.Ганбат Улсын Их Хурлын гишүүн, Н.Энхболд Улсын Их Хурлын гишүүн.

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр холбогдох байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг тухай бүр татан оролцуулахыг Ажлын хэсгийн ахлагчид зөвшөөрсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Тогтоолын төсөл нэгэнт тараагдсан. Дэд ажлын хэсэг дээр болбол Ажлын дэд хэсгийн ахлагч Чимгээ Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх, нарийн бичгийн дарга Гандиймаа Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хариуцсан референт, ажлын дэд хэсгийн гишүүд Ц.Баянмөнх

Улсын Их Хурлын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх, Ч.Гандиров Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа, М.Мөнхбаяр Батлан хамгаалах яамны Бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга, бригадын генерал, Г.Энхболд Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Хуулийн хэлтсийн дарга, хурандаа, Б.Түвшинтөр ЗХЖШ-ын Материал, техникийн газрын дарга, хурандаа гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байна.

Асуулт асуух гишүүн алга байна. Үг хэлэх гишүүн алга байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулж гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Энэ чинь 3 болно. Бямбацогт чинь биш байхгүй юу. Санал хураалт явуулъя. Ажлын хэсэг байгуулах тухай тогтоолын төслийг дэмжье, баталъя гэсэн томъёоллоор. 6 гишүүн дэмжиж, 60 хувийн саналаар уг тогтоолын төсөл дэмжигдлээ.

11.47 цаг

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Хуралдаанд идэвхтэй оролцсон Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсгийнхэнд баярлалаа. Хуралдаан өндөрлөлөө.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

